

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 1/303 тоот тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Хэрлэн сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.

3. Хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахыг Дорнод аймгийн Хэрлэн сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч компани, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Болор-Эрдэнэ/-нд даалгасугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 124 дугаар, “Тариф батлах тухай” 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 520 дугаар тогтоолуудыг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Баталгаажуулсан: Ажлын албаны дарга

Б.Болор-Эрдэнэ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дүгээр тогтоолын хавсралт

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ

1. Хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал		Хэмжих нэгж	Тариф	
1	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн халаалт		Төг/м ³	984.00	
2	Хэмжүүрээр тооцох дулаан		Төг/ГДж	8,573.00	
3	Орон сууцны халаалт		Төг/м ²	648.00	
			Төг/ГДж	6,328.00	
4	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	2,394.00
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	3,592.00
		Усны зарцуулалтаар		Төг/м ³	3,200.00
		Хэмжүүрээр тооцох		Төг/ГДж	4,818.00
5	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф				
5.1	40 м ² хүртэл талбайтай айл өрх		Төг/сар	4,224.00	
5.2	41 м ² -аас 80 м ² хүртэл талбайтай айл өрх		Төг/сар	7,040.00	
5.3	81 м ² -аас дээш талбайтай айл өрх		Төг/сар	14,080.00	